



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 19 едэр

Дугаар А/876

Улаанбаатар хот

Г Сармагчны цэцэг өвчний тандалт,
оношилгоо, эмчилгээний түр заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.5, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сармагчны цэцэг өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний түр зааврыг нэгдүгээр, Сармагчны цэцэг өвчний лабораторийн оношилгооны түр зааврыг хоёрдугаар, Сармагчны цэцэг өвчний оношилгоо, эмчилгээний түр зааврыг гуравдугаар хавсралтаар, Сармагчны цэцэг өвчний тархвар судлалын хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Сармагчны цэцэг өвчний үед нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Сувд/, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141221789

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
07 сарын 19-ны өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

САРМАГЧНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ТАНДАЛТ, СЭРГИЙЛЭЛТ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТҮР ЗААВАР

Нэг. Үндэслэл

1.1. Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД)-ийн зохицуулагч байгууллагын мэдээгээр 2022 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-д сармагчны цэцэг өвчний зөөвөрлөгдсөн анхны тохиолдол бүртгэгдсэнээс хойш Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын 5 бүсийн 69 улс орон, нутаг дэвсгэрт уг өвчний лабораториор батлагдсан 13,340 тохиолдол бүртгэгдээд байна. Эдгээр тохиолдол нь сармагчны цэцэг өвчин нутагшмал бус улс оронд бүртгэгдэж, тархалтын цар хүрээ богино хугацаанд нэмэгдэж байгаагаар “хэвийн бус” юм.

1.2. Монгол Улсын салбар хоорондын байгууллагууд оролцсон хамтарсан эрсдэлийн үнэлгээгээр сармагчны цэцэг өвчин Монгол улсад орж ирэх эрсдэл “Дунд” зэрэг байна.

1.3. Сармагчны цэцэг өвчний тандалт, оношилгоо, эмчилгээ, хариу арга хэмжээг зохион байгуулахад энэхүү зааврыг баримтлан ажиллана.

Хоёр. Сармагчны цэцэг өвчний тархвар судлал

2.1. Үүсгэгч

2.1.1. Сармагчны цэцэг өвчин нь *Poxviridae* овгийн *Orthopoxvirus* зүйлийн вирусийн сармагчны вирусээр үүсгэгддэг.

2.1.2. Сармагчны цэцэг өвчний үүсгэгч вирус нь Баруун Африкийн болон Төв Африкийн (Конгогийн сав газрын) гэсэн 2 ангилалд хуваагддаг. Уг вирусийг 1958 онд Дани улсад сармагчнаас илрүүлсэн ба 1970 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад анх хүн өвчилсөн мэдээлэл байдаг.

2.2. Халдвартын эх уурхай

2.2.1. Сармагчны цэцэг өвчнөөр Африкийн ойн хэрэм, харх зэрэг олон төрлийн амьтад өвчилдөг ба байгаль дээрх вирусийн эргэлт одоог хүртэл тодорхойгүй байна.

2.2.2. Халдвартын эх уурхай нь өвчтэй хүн, амьтан байна.

2.3. Халдвартамжих зам

2.3.1. Хүнээс хүнд:

а) Дуслын зам: Сармагчны цэцэг өвчний халдварт авсан хүнтэй ойрын зайд харьцахад үед халдварт авна.

б) Шууд болон шууд бус хавьтлын зам - Халдвартай хүний шарх, шархны тав, шүүдсэнд хүрэх эсвэл өвчтэй хүний хэрэглэж байгаа эд юмс, тусlamж үйлчилгээнд ашигласан бохир багаж, хэрэгслээр халдвар дамжина.

2.3.2. Амьтнаас хүнд: халдвартай амьтны биологийн шингэнтэй харьцах үед, өвчлөх эрсдэлтэй амьтны мах, махан бүтээгдэхүүнийг түүхийгээр хэрэглэх үед халдвар дамжина.

2.4. Нууц үеийн хугацаа

Нууц үеийн хугацаа 6-13 хоног, гэхдээ 21 хоног хүртэл байж болно.

2.5. Халдвартай үе

Тууралт гарснаас хойш шархны тав унах хүртэл хугацаа буюу дунджаар 21 хоног байна.

2.6. Халдварт өртөх эрсдэлтэй хүн ам

Бүх хүн өртөх эрсдэлтэй. Бага насын хүүхдүүд, дархлаа дутмагшлын өвчтэй хүмүүс илүү өртөж, хүндрэх эрсдэлтэй.

2.7. Тохиолдлын тодорхойлолт¹

2.7.1. Сэжигтэй тохиолдол:

2022 оны 6 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шалтгаан нь тодорхойгүй цочмог тууралттай ямар ч насын хүн

БА

2022 оны 3-р сарын 15-наас хойш дараах шинж тэмдгээс 3 ба түүнээс дээш шинж илэрсэн:

- Толгой өвдөх
- 38,5-аас дээш хэм хүрч халуурах
- Тунгалгийн булчирхай цочих
- Булчин өвдөх
- Нуруу өвдөх
- Ядарч сульдах

БА

Тууралтын шалтгаан нь дараах өвчин эмгэгийн тууралт биш байх: Үүнд: Салхинцэцэг, Бүслүүр үлд, Улаанбурхан, Херпес, Бактерийн шалтгаант арьсны халдвар, тархмал Заг хүйтний халдвар, нэг ба хоёрдугаар үеийн тэмбүүгийн тууралт, арьсны шархлаа, лимфогранулома, харшлын шалтгаант тууралт болон бусад өвчин эмгэгийн шалтгаант тууралт биш байх.

2.7.2. Магадлалтай тохиолдол:

Сэжигтэй тохиолдлын тодорхойлолттой ижил

¹ <https://www.who.int/publications/i/item/WHO-MPR-Surveillance-2022.2>

БА

Дараах зүйлсийн нэг ба түүнээс дээш:

- Шинж тэмдэг илрэхээс 21 хоногийн өмнө магадлалтай эсвэл батлагдсан тохиолдолтой хавьтал болсон (нүүр тулж уулзсан хүн, хамгаалах хувцас, хэрэгсэлгүй харьцсан эрүүл мэндийн ажилтан, арьс ба арьсны тууралтад хүрсэн, бэлгийн хавьтал, бохирдсон эд зүйлс болох хувцас, цагаан хэрэглэл аяга таваганд хүрсэн..)
- Шинж тэмдэг илрэхээс өмнөх 21 хоногт сармагчны цэцэг өвчний эсрэг бие эерэг хэд хэдэн эсвэл танихгүй этгээдтэй бэлгийн хавьталд орсон; эсхүл цочмог (5-7 дахь өдөр хүртэл) болон эдгэрэлтийн (21 дэх өдөр) үед авсан сорьцод үндэслэн IgG эсрэгбиейн титр дөрөв дахин нэмэгдсэн;
- Салхин цэцэг өвчний эсрэг вакцин хийлгээгүй эсхүл өөр эрсдэлд өртөөгүй ч ортопоксвирусийн ийлдэс судлалын шинжилгээний зерэг үр дүн гарсан.

2.7.3. Батлагдсан тохиолдол:

Бх-ПГУ-ын шинжилгээ эсхүл генийн дараалал тогтоох шинжилгээгээр сармагчны цэцэг өвчний вирус илэрсэн.

2.8. Хавьтлын тодорхойлолт:

Батлагдсан тохиолдлын шинж тэмдэг илэрч эхлэснээс тууралт нь бүрэн эдгэрэх хүртэл хугацаанд дараах маягаар хавьтсан хүнийг хавьтал гэж тодорхойлно:

- Арьснаас арьсанд шууд хүрэлцсэн (хүрэх, тэврэх, үнсэх, дотно харилцаанд орох г.м);
- Хувцас, орны даавуу, бохирдсон өрөөг цэвэрлэхэд ашиглах цэвэрлэгээний даавуу гэх мэт бохирдсон эд зүйлстэй хавьтсан;
- Ойрхон зайд нүүр тулж уулзсан;
- Халдвартай хүнтэй ойр зайд хувийн хамгаалах хувцас, хэрэгсэлгүйгээр харьцсан эрүүл мэндийн ажилтан хамаарна.

2.9. Тусгаарлалтын хугацаа:

- 2.9.1. Батлагдсан тохиолдлыг 21 хоногийн турш тусгаарлан эмчилнэ.
- 2.9.2. Хавьтлыг батлагдсан тохиолдолтой хамгийн сүүлд харьцсан өдрөөс хойш 21 хоногийн турш эмнэлзүйн тандалт хийж гэрээр тусгаарлана.

Гурав. Сармагчны цэцэг өвчний бэлэн байдлыг хангах чиглэлээр бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 3.1. Сармагчны цэцэг өвчнөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх;
- 3.2. Сармагчны цэцэг өвчний үед хэрэглэх яаралтай тусlamжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуур, урвалж, халдвартгүйжүүлэх бодисын нөөцийн бэлэн байдлыг хангах;

3.3. Сармагчны цэцэг өвчний талаарх мэдээ, мэдээллээр иргэдийг хангах, эрсдэлийн мэдээлэл, харилцааг удирдан зохион байгуулах;

3.4. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад халдвараас сэргийлэх дэглэм, ялан оношлогоо, тандалт, хариу арга хэмжээний талаар сургалт хийх;

3.5. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүмүүсийн дунд халууралт тууралттай, халууралт цэврүүт тууралттай хам шинжийн тандалтыг сайжруулж халдварт өвчний эрт сээрэмжлүүлэг хариу арга хэмжээний тандалт (EWAR-2.0)-аар 7 хоног тутам мэдээлэх, босго үзүүлэлтээс давсан тохиолдолд 24 цаг дотор мэдээлэх. Тухайн хамшинжийн оношийг баталгаажуулж, тандалт хийж, ямар нэгэн өвчний онош батлагдсан тохиолдолд яаралтай мэдээлэх хуудасны 2 дахь хэсгийг бөглөн EWAR-2.0 програмд оруулж байх;

3.6. Эрүүл мэндийн байгууллагуудын тусгаарлан эмчлэх тасгийн бэлэн байдлыг хангах;

3.7. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед тусгаарлан эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх, сорьц цуглуулах, шинжилгээ хийх, тархвар судалгаа хийх, эх уурхай, хавьтал тогтоох зэрэг шуурхай хариу арга хэмжээ авч ажиллах.

Дөрөв. Хилийн нэвтрэх цэгийн тандалт:

4.1. Хилийн нэвтрэх цэгт сармагчны цэцэг өвчинеэс сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах;

4.2. Хилийн нэвтрэх цэгт сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдвартгүйжүүлэлтийн багаж, бодис, эмийн нөөцийг МХЕГ-ын даргын 2018 оны “Заавар батлах тухай” А/192 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан шаардлагын дагуу бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

4.3. Агаарын хилийн боомт дээр Иргэний нисэхийн ерөнхий газрын дэргэдэх APIS (Advance passenger information system) цахим программын тусlamжтайгаар өвчлөл бүртгэгдэж байгаа улс орноос ирэх зорчигчийн мэдээллийг урьдчилан авч, хариу арга хэмжээг төлөвлөх;

4.4. Онгоцны нисэх багийн даргаас зорчигчийн эрүүл мэндийн ерөнхий мэдүүлэг, (general declaration form) галт тэрэгний дарга, үйлчлэгч, автобус, автомашины жолоочоос зорчигчийн эрүүл мэндийн мэдээлэл, зорчигчийн тоо, суудлын дугаар бүхий нэрсийн жагсаалтын хамт авч, хяналт тандалт хийх төлөвлөлтийг зохион байгуулах;

4.5. Улсын хилийн боомтоор нэвтэрч буй зорчигч, жолооч, нислэгийн баг бүрэлдэхүүн, галт тэрэг, вагоны дарга, үйлчлэгч, төмөр замын хөлөг ажилтнаас “Зорчигчийн эрүүл мэндийн мэдүүлэг”-ийг (цахим хэлбэр) авч, биеийн халууныг хэмжин, хяналт тандалт хийх.

Тав. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээнд мөрдөх халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаа:

5.1. Сармагчны цэцэг өвчний сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд тусlamж үзүүлэхдээ стандарт, хавьтал, дуслын сэргийлэлтийн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах;

5.2. Эрүүл мэндийн байгууллагад хүчин төгөлдөр хэрэгжиж буй халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлын менежментийн журам, зааврыг (ЭМС-ын 2019 оны A/537, A/539, 2017 оны A/505 тоот тушаал) мөрдөж ажиллах;

5.3. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүн бүрийг эрсдэлтэйд тооцон тусlamж үйлчилгээний төрөл, хэлбэрээс үл хамааран эмнэлгийн бүх ажиллагсад амны хаалт зүүх, гарын эрүүл ахуйг сайтар сахих;

5.4. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчид, хэвтэн эмчлүүлэгчдийн дунд тууралтат халдварын шинж тэмдгийн тандалтыг өдөр бүр хийх, сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх, тусгаарлах, тандалт хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллах;

5.5. Сэжигтэй тохиолдлыг нэг, нэгээр нь тусгаарлана. Хэрэв ижил шинж тэмдэг бүхий нэгээс дээш хүнийг нэг өрөөнд тусгаарлах бол ор хоорондын зай 1.5-2 метрээс дээш байх ба ор хооронд тусгаарлагч ашиглана. Хөдөө, орон нутагт тусгаарлах өрөөнд биосуултуур, гоожуурт угаагуур, гадаа жорлон ашиглаж болно.

5.6. Гар их хүрэлцдэг, бохирдох эрсдэл ихтэй талбай, эд зүйлсийн гадаргууг өдөрт 2-3 удаа арчиж халдвартайжүүлэх;

5.7. Агаар сэлгэлтийг тогтмол, 2 цаг тутам 10-15 минут хийх;

5.8. Сармагчны цэцэг өвчний халдварын сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд тусlamж үзүүлэх эрүүл мэндийн ажилтан дараах хамгаалах хувцас өмсөнө.

- Нэг удаагийн халад
- Нэг удаагийн амны хаалт
- Бээлий
- Нүдний шил эсвэл нүүрний хаалтыг зөв өмсөж, аюулгүй тайлна.
- Аэрозол үүсгэх ажилбар гүйцэтгэх үед нэмэлтээр зориулалтын 95 хувь буюу түүнээс дээш шүүлтүүртэй (N95, FFP2, FFP3) амны хаалт хэрэглэнэ.

5.9. Нэг удаагийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийг давтан хэрэглэхгүй, тусlamж үйлчилгээ үзүүлсний дараа, бохирдсон тухай бүр хувцас тайлах хэсэгт шууд тайлна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
07. сарын 19-ны өдрийн 14 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

САРМАГЧНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ЛАБОРАТОРИЙН ОНОШИЛГООНЫ ТҮР ЗААВАР

Нэг. Сорьц цуглуулалт, тээвэрлэлт, хадгалалт

1.1. Сармагчны цэцэг өвчний сэжигтэй тохиолдлоос эмнэлзүйн сорьц авахдаа арьсны гэмтсэн хэсгээс ялгарсан шүүрлээс, тууралтын нэг эсвэл хэд хэдэн цэврүүний шингэнээс, шархны өнгөрөөс арчдас авч вирус тээвэрлэх орчинд хийнэ. Хангалттай хэмжээний сорьц авахын тулд гэмтсэн хэсгийг бамбараар даралттай арчиж авна. Арьсны шархны тавыг хуурай шилэнд нэмэлтээр авч болно. Арьсны шарх болон цэврүүт тууралт байхгүй тохиолдолд хоолойн арчдас авч болно.

1.2. Судалгааны зорилгоор нэмэлтээр шээс, үрийн шингэн, бэлэг эрхтний арчдас авч шинжилж болно.

1.3. Шинжилсэн сорьцууд эргэлзээтэй үр дүнг үзүүлж байгаа тохиолдолд цусанд IgM илрүүлэх, эсхүл багадаа 21 хоногийн зйтай цуглуулсан цусны хос ийлдсэнд IgG илрүүлэх шинжилгээ хийж оношийг баталгаажуулна.

1.4. Ойрын хугацаанд вакцинд хамрагдсан бол ийлдэс судлалын шинжилгээнд хуурамч зэрэг хариу гаргах боломжтой.

Хоёр. Сорьцын хадгалалт, савалт, тээвэрлэлт

2.1. Сорьцыг цуглуулснаас хойш нэг цагийн дотор хөргөгч эсвэл хөлдөөгчид хадгалах ба аль болох хурдан хугацаанд лабораторид тээвэрлэнэ. Сорьц тээвэрлэхдээ гуравласан савлагааны зарчмыг баримтлах ба дагалдах хуудсыг гаргацтай бүрэн бүрэн бөглөсөн байна.

2.2. Сорьцыг цуглуулснаас хойш нэг цагийн дотор 2-8°C хэмд, 7 хоногийн дотор -20°C хэмд хадгална. Сорьцыг 7 хоногоос удаан хугацаагаар хадгалах бол -70°C хэмийн гүн хөлдөөгчид хадгална. Хөлдөөсөн сорьцыг гэсгээхгүйгээр тээвэрлэж лабораторид хүргүүлнэ (Хүснэгт №1).

Гурав. Лабораторийн шинжилгээний аргачлал

3.1. Үүсгэгч илрүүлэх шинжилгээг холбогдох техникийн болон аюулгүй ажиллагааны заавар, журмын сургалтад хамрагдсан ажилтнууд, зохих түвшинд тоноглогдсон лабораторид гүйцэтгэнэ.

3.2. Үүсгэгчийг баталгаажуулах шинжилгээг хийхдээ вирусийн ДНХ-ийн өвөрмөц нуклеотидын дарааллыг илрүүлэх бодит хугацааны эсвэл уламжлалт полимеразын гинжин урвалын аргыг ашиглана. ПГУ-ын аргачлалаар ерөнхий *Orthopoxvirus*-ийн төрөл болон сармагчны цэцэг өвчний вирусийг илрүүлнэ.

Хүснэгт №1. Сорьц цуглуулалт, хадгалалт

Сорьцын төрөл	Цуглуулах материал	Хадгалах нөхцөл	Ашиглалтын зорилго
- Арьсны шарх, тууралтат хэсэг - Шархны шүүрлээс авсан арчдас - Шарх, тууралтын өнгөрийн арчдас - Шархны тав	- Вирус тээвэрлэх орчинтой эсвэл хуурай хуруу шил - Пластик иштэй хатуу, ариун бамбар		Оношилгооны зориулалтаар ашиглана
Хоолойн арчдас	- Вирус тээвэрлэх орчинтой эсвэл хуурай хуруу шил - Пластик иштэй хатуу, ариун бамбар	- Цуглуулснаас хойш нэг цагийн дотор 2-8°C хэмд, эсвэл -20°C хэмийн хөлдөөгчид - 7 хоногоос удаан хадгалах бол -20°C-ос -70°C хэмийн хөлдөөгчид	Арьсны шархалсан, тууралтат хэсгийн сорьцоос гадна нэмэлтээр цуглуулсан бол оношилгоонд ашиглана
Шулуун гэдэс болон бэлэг эрхтэний арчдас	- Вирус тээвэрлэх орчинтой эсвэл хуурай хуруу шил - Пластик иштэй хатуу, ариун бамбар		Судалгааны зориулалтаар ашиглаж болно (ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх)
Шээс	Зориулалтын ариун сав		Судалгааны зориулалтаар ашиглаж болно (ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх)
Үрийн шингэн	Зориулалтын ариун сав	- 1 цагийн дотор өрөөний хэмд - 1 цагаас дээш хадгалах бол -20°C ба түүнээс хүйтэн нөхцөлд	Судалгааны зориулалтаар ашиглаж болно (ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх)
Цус	ЭДТА агуулсан ариун хуруу шил (ягаан тагтай)		Судалгааны зориулалтаар ашиглаж болно (ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх)
Ийлдэс	Ийлдэс тусгаарлагчтай хуруу шил (шар тагтай)	- Цуглуулснаас хойш нэг цагийн дотор (2-8°C хэмийн хөргөгчинд) - Нэг цагаас удаан хадгалвал -20°C хэмийн хөлдөөгчид - 7 хоногоос дээш хадгалах бол 20°C ба түүнээс хүйтэн нөхцөлд	Оношилгоо, судалгаанд нэмэлт баталгаа болгох үүднээс ийлдэс судлалын шинжилгээний зориулалтаар ашиглах (ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх)
Сийвэн	ЭДТА агуулсан хуруу шил (ягаан тагтай)		Оношилгоо, судалгаанд нэмэлт баталгаа болгох үүднээс ийлдэс судлалын шинжилгээний зориулалтаар ашиглах (ёс зүйн удирдамжийг дагаж мөрдөх)

Эрүүл мэндийн сайдын 2022 оны
07. сарын 19..-ны өдрийн 11 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

САРМАГЧНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ОНОШИЛГОО,
ЭМЧИЛГЭЭНИЙ ТҮР ЗААВАР

Нэг. Зорилго

1.1. Сармагчны цэцэг өвчний сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, оношлох, шинжлэх, тусгаарлах, халдвартай өвчтөнд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд эрүүл мэндийн ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангахад оршино.

**Хоёр. Сармагчны цэцэг өвчний эрт илрүүлэг,
эрэмбэлэн ангилалт**

2.1. Сармагчны цэцэг өвчний сэжигтэй тохиолдол хандсан хамгийн эхний эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгж нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа халдвартын тандалт, сэргийлэлтийн зааврын дагуу тархварзүйн асуумж, эмнэлзүйн шинжүүдээр илрүүлэн таньж тусгаарлана.

2.2. Цочмог халдварт өвчний үед үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн үндсэн зарчмыг баримтлан эмчилгээг цаг алдалгүй эхлүүлнэ.

2.3. Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тогтвортжуулсны дараа тохирох эмчилгээ, тусламж үзүүлэх эрэмбийг тодорхойлж цаашдын шийдвэрийг гаргана.

2.4. Сармагчны цэцэг өвчний сэжигтэй тохиолдолтой харьцахдаа дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Халдвараас сэргийлэх дэглэмийг баримтлан эмнэлзүйн тандалт хийх;
- Тархвар судлалын асуумж судалгааг авах, ойр дотны хүмүүст нь адил шинж тэмдэг илэрсэн хүн байсан эсэхийг тодруулах;
- Сэжигтэй тохиолдоос сорьц авч лабораторид илгээх.

Гурав. Оношилгоо

Оношийн ангилал:

Сармагчны цэцэг өвчин ОУΘА-10 ангиллын дагуу В04 гэж бичнэ.

3.1. Эмнэлзүйн илрэл

3.1.1. Урьдал үе: Эмнэлзүйн шинж тэмдгүүд илэрч эхэлнэ. Үүнд: халуурах, ядарч сульдах, толгой өвдөх, зарим тохиолдолд хоолой өвдөх, ханиах, тунгалгийн булчирхай томрох ба тунгалгийн булчирхай томрох нь халууралттай хамт, тууралт гарахаас 1-2 хоногийн өмнө эсвэл цөөн тохиолдолд тууралттай хамт илэрдэг. Хүзүү, суга, цавины булчирхайнүүд томордог (Зураг 1).



Зураг 1. Тунгалгийн булчирхайн томролт

3.1.2. Ид үе: Өвчний хүндийн зэрэг нь халдварт орсон зам, өвчин үүсгэгчийн төрөл, зүйлээс хамаардаг. (Баруун Африкийн болон Төв Африкийн вирус).

3.1.2.1. Баруун Африкийн сармагчны цэцэг өвчний вирусээр үүсгэгдсэн үед өвчний явц хөнгөн, нас барагт цөөн, хүнээс хүнд халдварт дамжих нь хязгаарлагдмал байдаг.

3.1.2.2. Төв Африкийн сармагчны цэцэг өвчний үүсгэгчээр үүсгэгдсэн тохиолдолд өвчний явц хүнд, нас барагт өндөр байдаг. Эмнэлзүйн гол шинж тэмдэг нь халууралт эхэлснээс 1-3 хоногийн дотор тууралт гарч эхэлдэг. Тууралтын элемент нь толбот, гувдрүүт, цэврүүт тууралт байх ба тууралтын тоо нь цөөн тоотойгоос хэдэн мянган хүртэл шигүү гарч болно. Ам, хэлэн дээр шарх гарч эхэлнэ. Тууралт нь нүүр, мөчдөөр илүү их гардаг. Нийт тохиолдлын 95% нь нүүрээр, 75% нь хөлийн ул, гарын алгаар, 70%-д амны салст бүрхүүл, 30%-д бэлэг эрхтэн, 20%-д нүдний салст бүрхүүлд тууралт гардаг (Зураг 2).



Зураг 2. Тууралт

Тууралт нь дараах үе шатыг дамждаг. Үүнд:

- Тууралтын элемент нь толбот, гувдрүүт, цэврүүт, идээт тууралт гэсэн үе шатыг дамждаг.
- Салстын тууралт: Ам, хэлэн дээр эхлээд тууралт гарна.

- Нүүрнээс эхлээд гүвдрүүт тууралт гарч дараа нь 24 цагийн дотор гар, хөл, гарын алга, хөлийн улаар гарна.
- Тууралт нь нүүр, мөчдөөр их биенээс илүү гарна.
- Тууралтын 3 дахь өдөр гүвдрүүт, тунгалаг шингэнээр дүүрсэн, гүн байршсан байна.
- Тууралтын 4-5 дахь өдөр цэврүүт тууралт гарна.
- Тууралтын 6-7 дахь өдөр идээт, хоорондоо нийлсэн байдалтай болно.
- Хоёр долоо хоногт тууралт хатаж, тавшина (Зураг 3).



Зураг 3. Тууралтын үе шат

Дөрөв. Хүндрэл

- Хоёрдогч халдварт
- Бронхопневмони
- Үжил
- Энцефалит
- Хараа муудах /нүдний угийн халдварт үрэвсэл/

Тав. Ялган оношилгоо

Сармагчны цэцэг өвчнийг дараах өвчнүүдээс ялган оношилно. Үүнд:

5.1. Салхин цэцэг: Сармагчны цэцэг өвчний тууралтын үе шат, элемент зэрэг адилхан боловч салхинцэцэг өвчний үед бүх биеэр тууралт гардаг бол сармагчны цэцэг өвчний үед нүүр, мөчид, гарын алга, хөлийн улаар илүү тархмал туурдаг. Халууралт сармагчны цэцэг өвчний үед 38.8 хэм түүнээс дээш байдаг бол салхинцэцэг өвчний үед халууралтгүй эсвэл бага зэрэг халуурна.

5.2. Цагаан цэцэг: Сармагчны цэцэг өвчний үед хүзүү, цавины тунгалгийн булчирхай томордог бол цагаанцэцэг өвчний үед энэхүү шинж бараг илэрдэггүй.

5.3. Тэмбүү: Уг өвчний үед хатуу яр нь цайвар трепонем нэвтрэн орсон газар ганц нэгээрээ гарах ба 2-3 түүнээс дээш тоотой байж болно. Дагалдах бубон буюу хатуу ярны ойролцоо тунгалгийн зангилаа томордог.

5.4. Орф вирусийн халдварт: Электрон микроскоопор харж тууралтын элементийг ялгахад сармагчны цэцэг өвчний үеийн тууралт нь бага зэрэг жижиг, гадаргуу нь зөв хэлбэртэй байдаг.

5.5. Бусад поксивирусийн халдварт, энгийн болон бэлгийн херпес, Моллюск контагиозум зэрэг өвчнөөс ялангошилно.

Зургаа. Эмчилгээ

6.1. Сармагчны цэцэг өвчин 2-4 долоо хоногийн хугацаанд аяндаа эдгэрэх боломжтой. Африкийн орнуудад нас баралт 1-10% байдаг нь хавсарсан өвчнөөс хамаарсан учир вирусийн эсрэг эмчилгээнээс гадна хавсарсан өвчний тохирсон эмчилгээг хийх шаардлагатай (Хүснэгт №2).

Хүснэгт №2. Вирусийн эсрэг эмийн схем

Эмүүд	Эмийн хэлбэр тун	Үйлдлийн механизм	Насанд хүрэгчдэд	Хүүхдэд	Анхаарах зүйл
Тековиримат (Tecovirimat)	200мг бүрээс	Ортопоксивирусийн уургийн нийлэгжилтийг дарангуйлах замаар эзэн биед вирус тархахыг хязгаарлах	4-120кг жинтэй бол 600мг 12 цагаар 14 хоног, ≥120кг жинтэй бол 600мг 8 цагаар 14 хоног	13-25 кг 200мг 12 цагаар 14 хоног 25-40кг 400мг 12 цагаар 14 хоног >40кг бол насанд хүрэгчидтэй ижил	Элэгний үйл ажиллагааг хянах Бөөрний дутагдлын үед тун зохицуулалт шаардлагагүй
Бринцидо-фовир Brincidofovir	100 мг шахмал; 10мг/мл хөвмөл	Ортопоксивирусийн ДНХ полимераза энзимийг сонгомлоор дарангуйлаа	≥48 кг бол 7 хоногт 1 удаа 2 тун (1 ба 8 дахь өдөр); <48 кг бол 4мг/кг –р тооцож ижил тун	<10кг бол хөвмөл 6мг/кг, 10-48кг 4мг/кг тунгаар тооцож 1 ба 8 дахь өдөр ууна	Элэгний үйл ажиллагааг хянах Бөөрний дутагдлын үед тун зохицуулалт шаардлагагүй Элэгний үрэвслийн үед ALT >8 дахин их үед зөвшилцэж хэрэглэх
Цидофовир Cidofovir	375мг/5мл тарилгын шингэн	Вирусийн ДНХ –н нийлэгжилтийг саатуулна	5мг/кг тунгаар тооцож	<18 настай бол аюулгүй байдал тодорхой бус	Бөөр гэмтээх нөлөөтэй.

	(75мг/мл)	Амьтанд хийсэн загвар судалгаанд үр нөлөө өгсөн	дуслаар 1 цагийн турш 7 хоногт 1 удаа нийт 2 тун		Суурь сийвэнгийн креатинин 0.3-0.4мг/дл байвал 3мг/кг -р тооцох, Креатинин >0.4мг/дл нэмэгдвэл эмчилгээг зогсоох Сийвэнгийн креатинин, шээсний уураг, лейкоцит, харааг хянах
--	-----------	---	--	--	--

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
07. сарын 19.-ны өдрийн дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

САРМАГЧНЫ ЦЭЦЭГ ӨВЧНИЙ ТАРХВАР СУДЛАЛЫН ХУУДАС

2a. ТОХИОЛДЛЫН ӨРТӨЛТ (оношлогдох эсвэл шинж тэмдэг илрэхээс өмнөх 3 хүртэлх долоо хоног)

(Тод = Тодорхойгүй)

3 долоо хоногийн огноо: [Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D]-с
[Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D] хүртэл

Өвчтөн ижил шинж тэмдэгтэй хүнтэй эсвэл өвчтэй хүнтэй хавьтал болсон уу; магадлалтай эсвэл батлагдсан тохиолдолтой

Тийм Үгүй Тод

Доорх асуултуудыг өөвчтөн дээрх асуултад тийм гэсэн үед л асууна.

Хэдэн удаа хавьтал болсон бэ?	<input type="checkbox"/> Хавьтал болсон нийт хугацаа хэд вэ? <input type="checkbox"/> <5 минут <input type="checkbox"/> 5<15 минут <input type="checkbox"/> 15 минут <1 цаг <input type="checkbox"/> 1<4 цаг <input type="checkbox"/> 4 цаг +
Анх хавьтал болсон огноо (суулийн 3 долоо хоногт)	[Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D]
Хамгийн сүүлийн хавьтал болсон огноо (суулийн 3 долоо хоногт)	[Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D]
Өртөлтийн тухай мэдээлэл: (тохирох бүгдийг сонгоно уу)	<input type="checkbox"/> Өөрх <input type="checkbox"/> Ажлын байр <input type="checkbox"/> Сургууль/цэцэрлэг <input type="checkbox"/> Эрүүл мэндийн үйлчилгээ (лабораторийн өртөлтийг оруулаад) <input type="checkbox"/> Шөнийн клуб/хувийн үдэшлэг/саунд бэлгийн харьцаанд орсон <input type="checkbox"/> Бэлгийн харьцаанд ороогүй баар/ресторан эсвэл бусад жижиг арга хэмжээ <input type="checkbox"/> Бэлгийн харьцаанд ороогүй томоохон арга хэмжээ (жишээ нь наадам эсвэл спортын арга хэмжээ) <input type="checkbox"/> Бэлгийн хавьталд орсон томоохон үйл явдал <input type="checkbox"/> Тодорхойгүй <input type="checkbox"/> Бусад, бичнэ үү:

<p>Өртөлт хаана болсон бэ? <i>(тохирох бүгдийг сонгоно уу)</i></p>	<input type="checkbox"/> Өрх <input type="checkbox"/> Ажлын байр <input type="checkbox"/> Сургууль/цэцэрлэг <input type="checkbox"/> Эрүүл мэндийн үйлчилгээ (лабораторийн өртөлтийг оруулах) <input type="checkbox"/> Баар <input type="checkbox"/> Зоогийн газар <input type="checkbox"/> Шөнийн клуб <input type="checkbox"/> Хувийн үдэшлэг <input type="checkbox"/> Баяр, наадам <input type="checkbox"/> Хаалттай орчинд тэмдэглэсэн баяр <input type="checkbox"/> Саун <input type="checkbox"/> Гадаа спортын арга хэмжээ <input type="checkbox"/> Хаалттай орчинд хийсэн спортын арга хэмжээ <input type="checkbox"/> Тодорхойгүй <input type="checkbox"/> Бусад, бичнэ үү: <hr/>								
<p>Өртөлтийн орчны мэдээлэл (нэр ба хаяг):</p>	<p>талаарх _____ <hr/> </p>								
<p>Хавьтал болсон байдал (тохирох бүгдийг сонгоно уу)</p>	<input type="checkbox"/> Ойр харьцсан (<1м зайдай боловч бие махбодид хүрэлцээгүй) <input type="checkbox"/> Биед хүрсэн боловч салстад хүрээгүй, бэлгийн харьцаанд ороогүй <input type="checkbox"/> Амнаас арьсанд хүрэх (үнсэх, аман секс) <input type="checkbox"/> Бэлгийн хавьталд орох <input type="checkbox"/> Бохирдсон материалтай (биенийн шингэн, эд зүйл, ор дэрний цагаан хэрэглэл гэх мэт) хүрэлцсэн боловч тохиолдолтой шууд хавьтал болоогүй <input type="checkbox"/> Тохиолдолтой холботойгоор хавьтал болсон эрүүл мэндийн ажилтан <input type="checkbox"/> Тодорхойгүй <input type="checkbox"/> Бусад, бичнэ үү <hr/>								
<p>2b. АЯЛАЛЫН ТҮҮХ (оношлогдох эсвэл шинж тэмдэг илэрхээс өмнөх 3 хүртэлх долоо хоног) (Тод = Тодорхойгүй)</p> <p>Өвчтөн сүүлийн 21 хоногт гадаад улс орноор аялсан уу? <input type="checkbox"/>Тийм <input type="checkbox"/>Үгүй <input type="checkbox"/>Тод Доорх асуултуудыг өвчтөн дээрх асуултад тийм гэсэн үед л асууна.</p> <table border="1"> <thead> <tr> <th>Улс</th> <th>Бүс</th> <th>Очсон огноо</th> <th>Гарсан огноо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1.</td> <td></td> <td> <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>M <input type="checkbox"/>M <input type="checkbox"/>D <input type="checkbox"/>D <input type="checkbox"/>D </td> <td> <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>Y <input type="checkbox"/>M <input type="checkbox"/>M <input type="checkbox"/>D <input type="checkbox"/>D </td> </tr> </tbody> </table>		Улс	Бүс	Очсон огноо	Гарсан огноо	1.		<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D	<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D
Улс	Бүс	Очсон огноо	Гарсан огноо						
1.		<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D	<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D						

2.		<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D	<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D
3.		<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D	<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D
4.		<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D	<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D
5.		<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D	<input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> Y <input type="checkbox"/> <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> M <input type="checkbox"/> <input type="checkbox"/> D <input type="checkbox"/> D

2с. БЭЛГИЙН ЗАН ҮЙЛ (оношлогдох эсвэл шинж тэмдэг илэрхээс өмнөх 3 хүртэлх долоо хоног) (Top = Тодорхойгүй)

Сүүлийн 3 долоо хоногт бэлгийн хавьтал болсон хамтрагчдын тоо

0 1 2-5 6-10 >10 Хэлэхийг хүсэхгүй байна Мэдээлэл байхгүй

Доорх асуултуудыг өвчтөнөөс хэрэв нэг ба түүнээс дээш бэлгийн хамтрагчтай бол асууна

Ямар хэлбэрээр бэлгийн хавьталд орсон бэ? <i>(тохигох бүгдийг сонгоно уу)</i>	<input type="checkbox"/> Шулуун гэдсээр (топ) <input type="checkbox"/> Шулуун гэдсээр (боттом) <input type="checkbox"/> Аман <input type="checkbox"/> Утрээ <input type="checkbox"/> Бусад (жишээ нь секстоглоом, г.м.) <hr/> <input type="checkbox"/> Хэлэхийг хүсэхгүй байна <input type="checkbox"/> Мэдээлэл байхгүй	Аюулгүй бэлгийн хавьтал <i>(эр эсвэл эм бэлгэвчийн хэрэглээ)</i>	<input type="checkbox"/> Тийм, үргэлж <input type="checkbox"/> Заримдаа <input type="checkbox"/> Үгүй, хэзээ ч үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй
	<input type="checkbox"/> Байнгын/гол сексийн хамтрагч (нөхөр, эхнэр, байнгын хамтрагч) <input type="checkbox"/> Хааяа уулздаг бэлгийн хамтрагч/ууд <input type="checkbox"/> Хааяа уулздаг үл таних бэлгийн хамтрагч/ууд (холбоо барих мэдээлэл байхгүй) <input type="checkbox"/> Бусад (бичнэ үү)		<input type="checkbox"/> Grindr <input type="checkbox"/> Scruff <input type="checkbox"/> Бусад танилцах апп <input type="checkbox"/> Баар/шөнийн клуб/олон нитийн үдэшлэг <input type="checkbox"/> Олон нийтийн газар (харанхуй өрөө, саун, секс клуб) <input type="checkbox"/> Хувийн секс үдэшлэг <input type="checkbox"/> Бусад, бичнэ үү:
Бэлгийн хамтрагчийн төрөл <i>(тохигох бүгдийг сонгоно уу)</i>	<input type="checkbox"/> Хэрэв бэлгийн хамтрагч нь хааяа уулздаг эсвэл үл таних хүн бол, өвчтөн тэдгээр хүмүүстэй хэрхэн учирсан бэ? <i>(тохигох бүгдийг сонгоно уу)</i>		

2d. Бусад өртөлт (оношлогдох эсвэл шинж тэмдэг илэрхээс өмнөх 3 хүртэлх долоо хоног) (Тод = Тодорхойгүй)

Тохиолдлын амьтантай хүрэлцсэн байдал:

(тохиорх бүгдийг сонгоно уу)

- Мэрэгчээс бусад гэрийн тэжээвэр амьтад
- Мэрэгч тэжээвэр амьтад (Гвиней гахай, хээр нохой, гербиль, хулгана, харх, хэрэм... гэх мэт)
- Мэрэгч амьтдаас бусад зэрлэг амьтад (сармагчин, амьд амьтан эсвэл үхсэн үхэр, зэрлэг ан / бутны мах гэх мэт)
- Зэрлэг эсвэл хотын мэрэгч амьтад (хэрэм, харх, дотуур байр, амьдрах орчинд байдаг, фермийн болон зэрлэг ан, амьтны шүүрхий мах, сэг зэм гэх мэт)
- Бусад (заавал)

Аялалаас үл хамааран оношлогдсон улсад шүүрхий махтай хүрэлцсэн байдал

Тийм Үгүй Тод
Тийм бол, байршлыг тодотгоно
уу

2e. Эмнэлгийн орчин дахь мэргэжлээс шалтгаалах өртөлт (оношлогдох эсвэл шинж тэмдэг илэрхээс өмнөх 3 хүртэлх долоо хоног) (Тод = Тодорхойгүй)

Хэрэв тохиолдол нь эмнэлгийн орчноос гадуур өртөлт болсон бол (2f) хэсэг рүү алгаснаа
уу

Эрүүл мэндийн ажилтны төрөл	Ажлын байр
Өвчтөн сармагчны цэцэг өвчтэй тохиолдолтой хэдэн удаа хавьтал болсон бэ?	<input type="checkbox"/> Ганц удаа <input type="checkbox"/> Олон удаа <input type="checkbox"/> МЭДЭГДЭХГҮЙ
Тохиолдолтой хавьтал болсон огноо (нууд)	[Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D] [Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D] [Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D] [Y][Y][Y][Y]/[M][M]/[D][D]
Боломжит өртөлтийн үед хувийн хамгаалах хэрэгсэл (XXX) хэрэглэсэн эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй
Ямар XXX хэрэглэсэн бэ?	<input type="checkbox"/> Бээлий <input type="checkbox"/> Комбинзон <input type="checkbox"/> Эмнэлгийн маск <input type="checkbox"/> Амны хаалт (N95, FFP2, г.м) <input type="checkbox"/> Нүүрний хаалт <input type="checkbox"/> Нүдний шил
Ажиллах эсвэл тайлах үед XXX гэмтсэн үү?	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Тодорхойгүй
Өртөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бичнэ үү (Шаардлагатай бол)	_____

**2f. дээрх мэдээлэлд үндэслэхэд, ХАМГИЙН БАЙЖ БОЛОХ ХАЛДВАРЫН ЗАМ
(Судлаач өртөлтийн талаарх мэдээлэлд үндэслэн шийднэ)**

- Хүнээс хүнд шууд дамжих (жирэмсэн үед болон төрөх үед эхээс хүүхдэд дамжихаас бусад), эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой эсвэл бэлгийн замаар дамжих
- Бэлгийн замаар дамжих
- Амьтнаас хүнд халдвартлах
- Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой (эрүүл мэндийн байгууллага эсвэл байгууллага эсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үед)
- Мэргэжлийн өртөлтийн улмаас лабораторид халдварт дамжих
- Жирэмсэн үед болон төрөх үед эхээс хүүхдэд дамжих
- Бохирдсон материалд хүрэх (жишээ нь ор дэрний цагаан хэрэглэл, хувцас, эд зүйл)
- Цус сэлбэх
- Бусад, бичнэ үү _____
- Тодорхойгүй

--000--